



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 16 өдөр

Дугаар А/516

Ховд

Эрх шилжүүлэх тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хог хаягдлыг ангилан ялгах, хогны менежментийг хэрэгжүүлэхэд зориулан 7 000 000 төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 7 000 000 төгрөг /долоон сая/-ийг аймгийн техник, хяналтын зардлаас санхүүжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/-д тус тус зөвшөөрсүгэй.

3. “Хог хаягдлыг ангилан ялгах, хогны менежментийг хэрэгжүүлэх ажил”-ын зардлыг хавсралтаар баталсугай.

4. Дээрх арга хэмжээг “Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээг худалдан авах тухай хууль”-ийн хүрээнд зохион байгуулж, гүйцэтгэгчтэй хамтран ажиллах гэрээг байгуулах, гүйцэтгэлд хяналт тавих, хүлээн авах, тайлагнах эрхийг Жаргалант сумын Засаг дарга /С.Гантөмөр/-д шилжүүлсүгэй.

5. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

Zax A/516 Ch

02 02295

51
Аймгийн Засаг даргын 2020 оны
09 дүгээр сарын 16-ны өдрийн
А/516 дугаар захирамжийн хавсралт

“ХОГ ХАЯГДЛЫГ АНГИЛАН ЯЛГАХ, ХОГНЫ МЕНЕЖМЕНТИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ”-ЫГ ГҮЙЦЭТГЭХ ЗАРДЛЫН ЖАГСААЛТ

№	Үйл ажиллагаа	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ /төг/	Нийт дүн /мян.төг/	Тайлбар
1	Хур хогийн цэгт хашаа татах	багц	1	6 000 000	6 000 000	1,6 м өндөртэй 3 м урттай төмөр торыг булан төмрөөр хүрээлүүлж, 3м тутамд 80мм-ийн ган турбаагаар шон хийж, шон дээрээ 1м урттай арматур төмрийг тогтоож, өргөстэй төмөр утсаар 3 эгнээ татсан байна. 3,5м урттай хаалгатай хийсэн байх. Гагнах болон суурилуулах ажлын хөлс тусгагдсан болно.
2	Дахин ашиглах хог хаягдлыг жинлэх жин /600кг/	ширхэг	1	1 000 000	1 000 000	60х80см-ийн хэмжээний тавцантай жин авах
Дүн					7 000 000	

-оОо-